



**Аудитын код: САГ-2018/159/СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер С. Оюунгэрэл  
Утас: 261885 Цахим хаяг: [oyungerels@audit.gov.mn](mailto:oyungerels@audit.gov.mn)

Ахлах аудитор Д. Цэрэндорж  
Утас: 261740 Цахим хаяг: [tserendorjd@audit.gov.mn](mailto:tserendorjd@audit.gov.mn)

“Эф Эл Эй Эс Эйч Аудит” ХХК-ийн захирал Ж. Отгонцэцэг  
Утас: 7000-0407 Цахим хаяг: [flashaudit1@gmail.com](mailto:flashaudit1@gmail.com)

Чанарын хяналтын мэргэжилтэн Ж. Энхцэцэг  
Утас: 7000-0806 Цахим хаяг: [flashaudit2@gmail.com](mailto:flashaudit2@gmail.com)


Аудитор Б. Баяндүүрэн  
Утас: 7000-0407 Цахим хаяг: [flashaudit1@gmail.com](mailto:flashaudit1@gmail.com)



**Улаанбаатар хот**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	
2. Аудитын тайлан.....	1
2.1 Оршил.....	1
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин.....	2
2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5 Дотоод хяналт.....	3
2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	3
2.7 Шилэн дансны мэдээлэл.....	3
2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	3
2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	3
2.9.1 Санхүүгийн тайлагналын талаар.....	3
2.9.2 Авлагын талаар.....	4
2.9.3 Үндсэн хөрөнгийн талаар.....	4
2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	5
2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	5
2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	5
2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	5
2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	5
3. Менежментийн захидал.....	6
3.1 Санхүүгийн тайлагналын талаар.....	8
3.2 Авлагын талаар.....	8
3.3 Үндсэн хөрөнгийн талаар.....	9
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/ өмч өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17





**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2018.02.23 № 06/414  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН  
ГАЛЕРЕЙН ЗАХИРЛЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
А.ЯНЖИВ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын уран зургийн галерейн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Монголын уран зургийн галерейн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монголын уран зургийн галерейн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

### Аудитын гол асуудал


2017 оны жилийн эцсийн тооллогод Түүх соёлын дурсгалт зүйлс 15,214,105.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хамруулаагүй, тооллогоор 7,902.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дутагдсаны эзэн холбогдогч тодорхой биш байна. 2008-2009 онд үүссэн 14,661.2 мянган төгрөгийн авлага байгаа зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, оршин байх, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц НАРАНЧИМЭГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2 Аудитын тайлан

### 2.1 Оршил

Монголын уран зургийн галерейн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Монголын уран зургийн галерейн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А. Янжив танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, үндсэн хөрөнгийн тооллогыг хуулийн дагуу хийх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын уран зургийн галерейн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд /САГ-2018/159/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Монголын уран зургийн галерейн төсвийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Монголын уран зургийн галерейн 2017 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 22-ноос 2018 оны 02 сарын 23-ны хооронд хийхээр төлөвлөн “Эф Эл Эй Эс Эйч Аудит” ХХК-ийн аудитор Б.Баяндүүрэн, аудиторовн туслах Э. Оюунтуяа нар гүйцэтгэж хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Монголын уран зургийн галерей төсвийн 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр №13 тоот албан бичгээр хуулийн хугацаанаас 1 хоног хоцроож “Эф Эл Эй Эс Эйч Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Эф Эл Эй Эс Эйч Аудит” ХХК аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 26-наас 2018 оны 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 23-нд Монголын уран зургийн галерейн удирдлагад гардуулна.

### **2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин**

Монголын уран зургийн галерей нь Монголын орчин үеийн дүрслэх урлагийн бүтээлүүдийг олон түмэнд сурталчлан танилцуулах зорилгоор 1991 онд Дүрслэх Урлагийн Музейгээс салж бие даан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Монголын уран зургийн галерей нь улсын бүртгэлийн 9070004010 тоот, регистрийн 9084789 тоот гэрчилгээтэй, Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо, Соёлын төв өргөөний Б корпусыг түрээслэн үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд тайлант хугацаанд нийт 13 орон тоотой ажилласан.

Монголын уран зургийн галерей нь үндсэн үйл ажиллагааны Төрийн сангийн банк дахь 100900035016 тоот, нэмэлт санхүүжилтийн 100900035411 тоот дансны баримтад 2015 оны 01 сарын 02-ноос 2017 оны 02 сарын 01 хүртэл захирал Н.Батбаатар, 2017 оны 04 сарын 05-наас одоог хүртэл захирал А.Янжив, хоёрдугаар гарын үсгийг 2016 оны 04 сарын 04-нөөс 2017 оны 07 сарын 24 хүртэл нягтлан бодогч Э.Батбаатар, 2017 оны 07 сарын 24-нөөс одоог хүртэл нягтлан бодогч С.Ариунаа нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулсан байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монголын уран зургийн галерейн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд /ТАБ-СТА-А-1/ маягтад тодорхой тусгасан.


Монголын уран зургийн галерейн төсвийн захирагч нь “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Соёлын тухай”, “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулиуд болон “Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага”-Монгол Улсын стандарт, Монгол Улсын сан хөмрөгийн дүрэм, бусад хууль тогтоомж болон БСШУСайдын 2009 оны 98 тоот тушаалаар батлагдсан “Улс, орон нутгийн музейн дүрэм”-ийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

### **2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Монголын уран зургийн галерейн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/



Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 25 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Acolous 3.0 санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

## 2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монголын уран зургийн галерей нь дотоод хяналтын нэгжгүй бөгөөд төлөвлөлтийн үед дотоод хяналтын эрсдэлийг дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хангалтгүй байна.

## 2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлж, төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Монголын уран зургийн галерейн төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс 277,304.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 23,263.4 мянган төгрөгийн орлого олжээ. Үүнээс урсгалд зардалд 294,757.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## 2.7 Шилэн дансны мэдээлэл

Монголын уран зургийн галерей нь “Шилэн дансны тухай” хуулийн дагуу 2017 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбар, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, 2018 оны төсвийн төсөл, зэрэг мэдээллийг өөрийн сайт болон [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд байршуулж байна.

## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 13 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр, нийт 25 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

2017 оны жилийн эцсийн тооллогод Түүх соёлын дурсгалт зүйлс 15,214,105.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хамруулаагүй, тооллогоор 7,902.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дутагдсаны эзэн холбогдогч тодорхой биш, 2008-2009 онд үүссэн 14,661.2 мянган төгрөгийн авлага байгаа зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, оршин байх, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

### 2.9.1 Санхүүгийн тайлагналын талаар

Тус байгууллага нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2018 оны 01 сарын 26 нд №13 тоот албан бичгийн хамт “Эф Эл Эй Эс Эйч Аудит” ХХК-д ирүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “Төсвийн шууд захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заалт, Сангийн сайдын 2006 оны 11 сарын 27-ны 388 дугаар тушаалыг тус тус хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөх

## 2.9.2 Авлагын талаар

Хувь хүмүүсээс авах авлага данс 14,961.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 14,961.2 мянган төгрөгийн авлагын эзэн холбогдогчийг тодорхойлж, нотлох баримтыг үндэслэн шийдвэрлэх талаар зөвлөмж өгөх

## 2.9.3 Үндсэн хөрөнгийн талаар

1. 2016 онд гаргасан үзэсгэлэнгийн үеэр “Бээжин Ли Спейс соёл, урлаг” ХХК-ын куратор Гү Зеикүны хандивласан гэх 42 инчийн 2ш телевизорыг хөрөнгийн бүртгэлд бүртгэж аваагүй бөгөөд тооллогын бүртгэлд анхны өртөггүй бүртгэгдсэн байна. Энэ нь УСНББОУС-17.23-т “Хөрөнгийг ямар ч өртөггүйгээр эсвэл нэрлэсэн өртгөөр олж авсан үед түүний өртөг нь худалдан авсан өдрийн бодит үнэ цэнэ болно” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тооллогын бүртгэлд байгаа 2ш Haier брендийн 42 инчийн телевизорыг зах зээлийн жишиг үнээр орлогодож бүртгэлд тусгах

2. Байгууллагын санхүүгийн байдлын тайланд бүртгэгдсэн боловч үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогоор дутсан 7,902.9 мянган төгрөгийн хөрөнгийн эзэн холбогдогч тодорхой биш байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцсийн тооллогоор дутсан 7,902.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн асуудлыг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгөх

3. Дүрслэх урлагийн музейн сан хөмрөгт бүртгэлтэй боловч сан хөмрөгөөс гадуур буюу “Их тэнгэрийн ам” төрийн тусгай хамгаалалттай газарт байрлах 34 дэсийн 34ш уран зургуудыг буцаан авах талаар 2011 оны 02 сарын 23-нд №13 тоот албан бичгээр байгууллагын захирал А.Чадраабал Их тэнгэр цогцолборын захиргаанд хүсэлт гаргасан. Их тэнгэр цогцолбороос 2011 оны 03 сарын 31 нд №56 тоот албан бичгээр “Нэр бүхий уран зургууд нь тус цогцолборын үндсэн хөрөнгөнд данстай бөгөөд гурван хамгаалуулагчийн байр, зочид буудалд байрлуулсан байдаг тул буцаан шилжүүлэх тухай асуудал байхгүй” гэсэн хариу албан тоот ирүүлсэн байна. Уг хариу албан тоотыг хавсралт болгон 2011 оны 04 сарын 06-нд №27 албан тоотоор Төрийн өмчийн хороонд уг асуудлыг шийдвэрлэх талаар хүсэлт гаргасан. 2011 оны 04 сарын 29 нд Төрийн өмчийн хорооноос №2/829 тоот албан бичгээр “Тусгай үйлчилгээний Их тэнгэр цогцолборын үндсэн хөрөнгөнд данстай нэр бүхий 34 уран бүтээл нь одоогийн байдлаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн өвлийн болон зуны өргөө, УИХ-ын даргын байр, Ерөнхий сайдын байр,



төрийн өндөр хэмжээний зочин хүлээн авдаг танхим зэрэг байруудад тараан байршуулсан байгаа ба гадаад дотоодын өндөр хэмжээний зочид төлөөлөгчдөд Монгол Улсын уран бүтээлчдийн бүтээлийг таниулан сурталчилж байдаг тул Уран зургийн галерейн сан хөмрөгт буцаан шилжүүлэх боломжгүй” гэсэн хариу ирсэн байна. Энэ нь оршин байх болон эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн хороонд хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх

## 2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

2017 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор Түүх соёлын дурсгалт зүйлс 15,214,105.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тооллогод хамруулаагүй байна.

## 2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Монголын уран зургийн галерейн санхүүгийн байдлын тайланд 2017 оны 12 сарын 31-нээр Түүх соёлын дурсгалт зүйлс данс 15,214,105.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Уг үлдэгдлийг биет тооллого хийж баталгаажуулаагүй тул дараагийн аудитаар хянах шаардлагатай гэж үзлээ.

## 2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Монголын уран зургийн галерейн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 22,864.10 мянган төгрөгийн зөрчил илэрснээс санхүүгийн тайланд залруулга хийгээгүй бөгөөд зөрчлийг дахин гаргахгүй байх талаар зөвлөмж өгсөн.

## 2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудиторын зөвлөмжийн биелэлт:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлсэн.
2. Хуримтлагдсан авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.
3. Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгүүдийг цаашид хэрхэн ашиглах талаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн арга хэмжээ авч ажиллах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.


## 2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Монголын уран зургийн галерейн санхүүгийн тайлан дахь материаллаг байдлын суурийг төлөвлөлтийн үе шатанд нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгийн дүн өндөр байгаа тул 382,687.5 мянган төгрөгийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгож материаллаг байдлыг 1 хувиар буюу 3,826.9 мянган төгрөгөөр тооцсон. Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн үеийн материаллаг байдлын төвшинг хэвээр нь авах нь зүйтэй гэж үзлээ.

## 2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эз төсвөд Монголын уран зургийн галерейн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.





## МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### Менежментийн захидал

#### Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1	
Санхүүгийн тайлагналын талаар.....	8
Асуудал 2	
Авлагын талаар .....	8
Асуудал 3	
Үндсэн хөрөнгийн талаар .....	9



### **3 Менежментийн захидал**

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Монголын уран зургийн галерейн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Санхүүгийн тайлагналын талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
<p><b><u>Аудиторын ажиглалт</u></b></p> <p>Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан хугацаанаас 1 хоног хоцроож 2018 оны 01 сарын 26 ны өдөр №13 тоот албан бичгийн хамт “Эф Эл Эй Эс Эйч Аудит” ХХК-д ирүүлсэн. Санхүүгийн тайлан иж бүрэн бус байсан.</p> <p><b><u>Эрсдэлүүд</u></b></p> <p>Санхүүгийн тайлан дутуу илэрхийлэгдэх /ИБ, ТТ/</p>	<p><b><u>Аудиторын зөвлөмж</u></b></p> <p>Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “Төсвийн шууд захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэх” заалт, Сангийн сайдын 2006 оны 11 сарын 27-ны 388 дугаар тушаалыг тус тус хэрэгжүүлж ажиллах.</p> <p>Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 сарын 25-ны дотор Үндэсний Аудитын газарт хүргүүлэх.</p> <p><b><u>Төсвийн захирагчийн хариу</u></b></p> <p>Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрч №25 тоот албан бичгээр хариу өгсөн болно.</p>
3.2 Авлагын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
<p><b><u>Аудиторын ажиглалт</u></b></p> <p>Хувь хүмүүсээс авах авлага данс 14,961.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.</p> <p><b><u>Эрсдэлүүд</u></b></p> <p>Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, найдваргүй авлага үүсэх /ЭҮ, ОБ/</p>	<p><b><u>Аудиторын зөвлөмж</u></b></p> <p>Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “ Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах, 14,961.2 мянган төгрөгийн авлагын эзэн холбогдогчийг тодорхойлж, нотлох баримтыг үндэслэн шийдвэрлэх.</p> <p>Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 сарын 25-ны дотор Үндэсний Аудитын газарт хүргүүлэх.</p> <div data-bbox="877 1697 1401 1854" style="border: 1px solid black; padding: 5px; text-align: center;"> <p>01 ХЯЗГААРЛАЛТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ Төсвийн захирагчийн хариу</p> </div> <p><b><u>Төсвийн захирагчийн хариу</u></b></p> <p>Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрч №25 тоот албан бичгээр хариу өгсөн болно.</p>

<b>3.3 Үндсэн хөрөнгийн талаар</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №3</b>
------------------------------------	----------------------------------

**Аудиторын ажиглалт**

1. 2016 онд гаргасан үзэсгэлэнгийн үеэр “Бээжин Ли Спейс соёл, урлаг” ХХК-ын куратор Гү Зеикүны хандивласан гэх 42 инчийн 2ш телевизорыг хөрөнгийн бүртгэлд бүртгэж аваагүй бөгөөд тооллогын бүртгэлд анхны өртөггүй бүртгэгдсэн байна.

2. Байгууллагын санхүүгийн байдлын тайланд бүртгэгдсэн боловч үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогоор дутсан 7,902.9 мянган төгрөгийн хөрөнгийн эзэн холбогдогч тодорхой биш байна.

3. Дүрслэх урлагийн музейн сан хөмрөгт бүртгэлтэй боловч сан хөмрөгөөс гадуур буюу “Их тэнгэрийн ам” төрийн тусгай хамгаалалттай газарт байрлах 34 дэсийн 34ш уран зургуудыг буцаан авах талаар 2011 оны 02 сарын 23-нд №13 тоот албан бичгээр байгууллагын захирал А.Чадраабал Их тэнгэр цогцолборын захиргаанд хүсэлт гаргасан. Их тэнгэр цогцолбороос 2011 оны 03 сарын 31 нд №56 тоот албан бичгээр “Нэр бүхий уран зургууд нь тус цогцолборын үндсэн хөрөнгөнд данстай бөгөөд гурван хамгаалуулагчийн байр, зочид буудалд байрлуулсан байдаг тул буцаан шилжүүлэх тухай асуудал байхгүй” гэсэн хариу албан тоот ирүүлсэн байна. Уг хариу албан тоотыг хавсралт болгон 2011 оны 04 сарын 06-нд №27 албан тоотоор Төрийн өмчийн хороонд уг асуудлыг шийдвэрлэх талаар хүсэлт гаргасан. 2011 оны 04 сарын 29 нд Төрийн өмчийн хорооноос №2/829 тоот албан бичгээр “Тусгай үйлчилгээний Их тэнгэр цогцолборын үндсэн хөрөнгөнд данстай нэр бүхий 34 уран бүтээл нь одоогийн байдлаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн өвлийн болон зуны өргөө, УИХ-ын даргын байр, Ерөнхий сайдын байр, төрийн өндөр хэмжээний зочин хүлээн авдаг танхим зэрэг байруудад тараан байршуулсан байгаа ба гадаад дотоодын өндөр хэмжээний зочид төлөөлөгчдөд Монгол Улсын уран бүтээлчдийн бүтээлийг таниулан сурталчилж байдаг тул Уран зургийн галерейн сан хөмрөгт буцаан шилжүүлэх боломжгүй” гэсэн хариу ирсэн байна. Энэ нь оршин байх болон эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлд нийцэхгүй байна.

**Аудиторын зөвлөмж**

1. Тооллогын бүртгэлд байгаа 2ш Haier брендийн 42 инчийн телевизорыг зах зээлийн жишиг үнээр орлогдож бүртгэлд тусгах. УСНББОУС-17.23-т “Хөрөнгийг ямар ч өртөггүйгээр эсвэл нэрлэсэн өртгөөр олж авсан үед түүний өртөг нь худалдан авсан өдрийн бодит үнэ цэнэ болно” гэсэн заалтыг мөрдөн ажиллах.

2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ” гэсэн заалтийг хэрэгжүүлж ажиллах, жилийн эцсийн тооллогоор дутсан 7,902.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн асуудлыг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх.

3. Төрийн өмчийн хороонд хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх

4. Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 сарын 25-ны дотор Үндэсний Аудитын газарт хүргүүлэх.



**Эрсдэлүүд**

Санхүүгийн байдлын тайлан дахь үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл бодит үнэ цэнээс өөрөөр тайлагнагдах, өөрийн эзэмшилд байхгүй үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг байгууллагын зардлаар бүртгэх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

/Ү, Х, ТИ, ҮЗ/

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрч №25 тоот албан бичгээр хариу өгсөн болно.



**4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл****4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

	<i>/төгрөгөөр/</i>	
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	108,760,104.19	99,660,994.19
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	0.00	0.00
АВЛАГА	14,661,154.69	14,961,154.69
Бусад авлага	14,661,154.69	14,961,154.69
Хувь хүмүүсээс авах авлага	14,661,154.69	14,961,154.69
БАРАА МАТЕРИАЛ	94,098,949.50	84,699,839.50
Түүхий эд материал	-	1,470,000.00
Тусгай зориулалттай материал	-	1,470,000.00
Хангамжийн материал	94,098,949.50	83,229,839.50
Бичиг хэргийн материал	8,910.00	24,880.00
Аж ахуйн материал	7,335,100.00	3,676,757.00
Бусад хангамжийн материал	86,754,939.50	79,528,202.50
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,223,699,111.69	15,265,559,548.55
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,223,699,111.69	15,265,559,548.55
Биет хөрөнгө	15,223,699,111.69	15,265,559,548.55
Авто тээврийн хэрэгсэл	18,057,500.00	18,057,500.00
Хуримтлагдсан элэгдэл	(1,805,750.04)	(3,611,500.08)
Машин, тоног төхөөрөмж	104,572,135.93	120,952,025.68
Хуримтлагдсан элэгдэл	(94,272,096.24)	(100,231,693.69)
Тавилга, аж ахуйн эд хогшил	79,187,393.41	79,187,393.41
Хуримтлагдсан элэгдэл	(57,373,953.37)	(64,758,058.77)
Түүх соёлын дурсгалт зүйлс	15,174,105,700.00	15,214,105,700.00
Номын фонд	1,228,182.00	1,858,182.00
Програм хангамж	1,370,000.00	1,370,000.00
Хасагдуулга	(1,370,000.00)	(1,370,000.00)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	15,332,459,215.88	15,365,220,542.74
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	273,975.30	273,975.30
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	273,975.30	273,975.30
Өглөг	273,975.30	273,975.30
Ажиллагчидтай холбогдсон өглөг	273,975.30	273,975.30
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	15,332,185,240.58	15,364,946,567.44
Засгийн газрын хувь оролцоо	15,332,185,240.58	15,364,946,567.44
Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	859,650,551.83	859,650,551.83
Өмч: -Төрийн өмч	859,650,551.83	859,650,551.83
Хуримтлагдсан үр дүн	157,810,452.75	190,571,779.61
Өмнөх үеийн үр дүн	157,810,452.75	157,810,452.75
Тайлант үеийн үр дүн	32,761,326.86	32,761,326.86
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	14,314,724,236.00	14,314,724,236.00
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	15,332,459,215.88	15,365,220,542.74

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	324,658,417.00	362,887,979.15
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,708,650.00	85,496,339.15
Нийтлэг татварын бус орлого	27,708,650.00	85,496,339.15
Төсөвт байгууллагын өөрийн орялого	27,708,650.00	81,743,339.15
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,276,010.00	11,357,000.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,432,640.00	11,906,449.40
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	58,479,889.75
Бусад орлого	-	3,753,000.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	296,949,767.00	277,391,640.00
Улсын төвлөрсөн төсвөөс	260,216,700.00	275,324,500.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	260,216,700.00	275,324,500.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	35,479,364.00	1,980,000.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	25,200,000.00	-
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан мөнгө	10,279,364.00	-
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,980,000.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	1,253,703.00	87,140.00
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,253,703.00	87,140.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	383,667,205.60	330,126,652.29
УРСГАЛ ЗАРДАЛ	357,295,350.29	324,229,156.09
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	357,295,350.29	324,229,156.09
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	110,372,504.00	109,752,680.00
Цалин	110,372,504.00	100,619,380.00
Унаа хоолны хөнгөлөлт	-	9,133,300.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,901,558.02	12,537,966.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	11,901,558.02	12,537,966.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,500,000.00	126,225,000.00
Байрны түрээс	127,500,000.00	126,225,000.00
Хангамж, бараа материалын зардал	30,008,548.67	26,518,607.80
Бичиг хэргийн материал	1,138,880.00	3,068,230.00
Шуудан холбоо интернетийн төлбөр	1,966,259.67	1,449,997.80
Ном, хэвлэлийн зардал	94,692.00	-
Хог хаягдал устгах, цэвэрлэх	-	545,300.00
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	26,808,717.00	21,455,080.00
Нормативт зардал	384,000.00	418,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	384,000.00	418,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	2,057,000.00	4,210,000.00
Урсгал засвар	2,057,000.00	4,210,000.00
Томилолт, зочны зардал	504,600.00	497,000.00
Дотоод томилолтын зардал	504,600.00	497,000.00



Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	21,450,000.00	24,748,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,450,000.00	24,748,000.00
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,000,000.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	53,117,139.60	19,321,902.29
Бараа үйлчилгээний бусад зардал	19,790,000.00	2,192,449.40
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	-	1,980,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,327,139.60	15,149,452.89
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,371,855.31	5,897,496.20
Бусад урсгал шилжүүлэг	-	3,900,000.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	3,900,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,371,855.31	1,997,496.20
Төвлөрүүлэх шилжүүлэг	26,371,855.31	1,997,496.20
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(59,008,788.60)	32,761,326.86
НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(59,008,788.60)	32,761,326.86



**4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	324,658,417.00	300,655,089.40
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,708,650.00	23,263,449.40
Нийтлэг татварын бус орлого	27,708,650.00	23,263,449.40
Төсөвт байгууллагын өөрийн орлого	27,708,650.00	23,263,449.40
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,276,010.00	11,357,000.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,432,640.00	11,906,449.40
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	296,949,767.00	277,391,640.00
Улсын төвлөрсөн төсвөөс	260,216,700.00	275,324,500.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	260,216,700.00	275,324,500.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	35,479,364.00	1,980,000.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	25,200,000.00	-
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан мөнгө	10,279,364.00	-
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,980,000.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,253,703.00	87,140.00
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,253,703.00	87,140.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	324,660,817.00	300,655,089.40
УРСГАЛ ЗАРДАЛ	324,660,817.00	300,655,089.40
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	298,288,961.69	294,757,593.20
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	110,372,504.00	109,752,680.00
Үндсэн цалин	101,146,904.00	100,619,380.00
Унаа хоолны хөнгөлөлт	9,225,600.00	9,133,300.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,901,558.02	12,537,966.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	11,901,558.02	12,537,966.00
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	127,500,000.00	126,225,000.00
Байрны түрээс	127,500,000.00	126,225,000.00
Хангамж, бараа материалын зардал	4,329,299.67	4,371,497.80
Бичиг хэрэг	937,840.00	1,509,200.00
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	1,966,259.67	1,449,997.80
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	545,300.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,425,200.00	867,000.00
Нормативт зардал	384,000.00	418,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	384,000.00	418,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	2,057,000.00	4,210,000.00
Урсгал засвар	2,057,000.00	4,210,000.00
Томилолт, зочны зардал	504,600.00	497,000.00
Дотоод албан томилолт	504,600.00	497,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,450,000.00	32,573,000.00

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	20,450,000.00	31,573,000.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	19,790,000.00	4,172,449.40
Бараа үйлчилгээний бусад зардал	19,790,000.00	2,192,449.40
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,980,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,371,855.31	5,897,496.20
Бусад урсгал шилжүүлэг	-	3,900,000.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	3,900,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,371,855.31	1,997,496.20
Төвлөрүүлэх шилжүүлэг	26,371,855.31	1,997,496.20
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (iii)=(i)-(ii)	(2,400.00)	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(2,400.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00



**4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/ өмч өөрчлөлтийн тайлан**

2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	859,650,551.83	14,314,724,236.00	157,810,452.75	15,332,185,240.58
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	859,650,551.83	14,314,724,236.00	157,810,452.75	15,332,185,240.58
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн				
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			32,761,326.86	32,761,326.86
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	859,650,551.83	14,314,724,236.00	190,571,779.61	15,364,946,567.44



#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
I. Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	298,745,000.00	294,398,003.80	4,346,996.20	98.5
Урсгал зардлын дүн	298,745,000.00	294,398,003.80	4,346,996.20	98.5
Бараа, үйлчилгээний зардал	294,845,000.00	290,498,003.80	4,346,996.20	98.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	110,085,800.00	109,665,540.00	420,260.00	99.6
Үндсэн цалин	100,952,500.00	100,532,240.00	420,260.00	99.6
Унаа, болон бусад нөхөн олговор	9,133,300.00	9,133,300.00	-	100
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,538,600.00	12,537,966.00	634.00	99.9
Тэтгэврийн даатгал	12,538,600.00	12,537,966.00	634.00	99.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	126,225,000.00	126,225,000.00	-	100
Байрны түрээс	126,225,000.00	126,225,000.00	-	100
Хангамж, бараа материалын зардал	4,628,000.00	4,371,497.80	256,502.20	94.5
Бичиг хэрэг	1,349,200.00	1,509,200.00	(160,000.00)	111.9
Шуудан холбоо, интернетийн төлбөр	2,206,400.00	1,449,997.80	756,402.20	65.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	545,300.00	545,300.00	-	100
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	527,100.00	867,000.00	(339,900.00)	164.5
Нормативт зардал	418,000.00	418,000.00	-	100
Нормын хувцас зөөлөн эдлэл	418,000.00	418,000.00	-	100
Эд хогшил худалдан авах	4,210,800.00	4,210,000.00	800.00	99.9
Урсгал засвар	4,210,800.00	4,210,000.00	800.00	99.9
Томилолт, зочны зардал	499,600.00	497,000.00	2,600.00	99.5
Дотоод албан томилолт	499,600.00	497,000.00	2,600.00	99.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	36,239,200.00	32,573,000.00	3,666,200.00	89.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,239,200.00	31,573,000.00	3,666,200.00	89.6
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,900,000.00	3,900,000.00	-	100.00
Бусад урсгал шилжүүлэг	3,900,000.00	3,900,000.00	-	100.00
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,900,000.00	3,900,000.00	-	100.00
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	298,745,000.00	294,398,003.80	4,346,996.20	98.54
Улсын төсвөөс санхүүжих	278,970,000.00	273,327,003.80	5,642,996.20	97.98


Улсын төсвөөс санхүүжих	278,970,000.00	273,327,003.80	5,642,996.20	97.98
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	19,775,000.00	21,071,000.00	(1,296,000.00)	106.55
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,775,000.00	9,377,000.00	398,000.00	95.93
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	11,694,000.00	(1,694,000.00)	116.94
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
Төсвийн бусад мэдээллийн ангилал	-	-	-	-
Байгууллагын тоо	-	-	-	-
Ажиллагсдын тоо	13.00	13.00	-	100.00
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.00
Үйлчлэх ажилтан	1.00	1.00	-	100.00

## НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
I. Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	1,980,000.00	(1,980,000.00)	-
Урсгал зардлын дүн	-	1,980,000.00	(1,980,000.00)	-
Бараа, үйлчилгээний зардал	-	1,980,000.00	(1,980,000.00)	-
Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,980,000.00	(1,980,000.00)	-
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,980,000.00	(1,980,000.00)	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	1,980,000.00	(1,980,000.00)	-
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,980,000.00	(1,980,000.00)	-
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,980,000.00	(1,980,000.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
Төсвийн бусад мэдээллийн ангилал	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	13.00	13.00	-	100.00
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.00
Үйлчлэх ажилтан	1.00	1.00	-	100.00



## ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОДРУУЛГЫН ТОХИРГОО

2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

Дансны нэр Нэр	Төсөв Дүн	Гүйцэтгэл		Тохируулсан Тохируулга	Төсвийн гүйцэтгэл	
		Зардал	Орлого		Зардал	Орлого
Үндсэн цалин	100,952,500.00	100,619,380.00	-	87,140.00	100,532,240.00	-
Тэтгэврийн даатгал	12,538,600.00	12,537,966.00	-	-	12,537,966.00	-
Унаа хоолны хөнгөлөлт	9,133,300.00	9,133,300.00	-	-	9,133,300.00	-
Байрны түрээс	126,225,000.00	126,225,000.00	-	-	126,225,000.00	-
Бичиг хэрэг	1,349,200.00	1,509,200.00	-	-	1,509,200.00	-
Шуудан холбоо интернетийн төлбөр	2,206,400.00	1,449,997.80	-	-	1,449,997.80	-
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,775,000.00	-	11,357,000.00	1,980,000.00	-	9,377,000.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал	545,300.00	545,300.00	-	-	545,300.00	-
Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	527,100.00	867,000.00	-	-	867,000.00	-
Нормын хувцас, зөөлөн эдлэл	418,000.00	418,000.00	-	-	418,000.00	-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	-	11,906,449.40	212,449.40	-	11,694,000.00
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	-	87,140.00	87,140.00	-	-
Урсгал засвар	4,210,800.00	4,210,000.00	-	-	4,210,000.00	-
Дотоод албан томилолт	499,600.00	497,000.00	-	-	497,000.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,360,300.00	8,695,000.00	-	-	8,695,000.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,870,900.00	3,870,000.00	-	-	3,870,000.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,008,000.00	19,008,000.00	-	-	19,008,000.00	-



Монголын уран зургийн галерейн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	-	-	1,000,000.00	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,900,000.00	3,900,000.00	-	-	3,900,000.00	-
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	239,830,800.00	-	275,324,500.00	1,997,496.20	-	273,327,003.80
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,360,300.00	-	-	-	-	-
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,870,900.00	-	-	-	-	-
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	19,008,000.00	-	-	-	-	-
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,900,000.00	-	-	-	-	-
Төвлөрүүлэх шилжүүлэг /Улсын төсөв/	-	1,997,496.20	-	1,997,496.20	-	-
Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,996,383.40	-	1,996,383.40	-	-
Бараа үйлчилгээний бусад зардал	-	196,066.00	-	196,066.00	-	-
Үндсэн данс	-	0.00	-	-	0.00	-

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ



